

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХЭД ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ МЭДЛЭГИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВРЫН ГҮЙЦЭТГЭЛ, ДҮГНЭСЭН АРГАЧЛАЛ

№	Шалгах үзүүлэлт	Даалгаврын гүйцэтгэл	Өгөх үнэлгээ	
1	Давж заалдах гомдол гаргахад хуулиар тогтоосон хэлбэр, агуулгын шаардлагыг хангасан байдал (ЗХШШтХ-ийн 115 дугаар зүйлийн 115.2 дахь хэсэг)			
	- гомдлыг ямар шүүхэд гаргаж байгааг даалгаврын өгөгдөлд нийцүүлэн зөв бичсэн эсэх	ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХЭД		0-3
	- гомдол гаргагч этгээдийн мэдээллийг хуульд заасан шаардлагын дагуу бичсэн бүрэн тусгасан эсэх	Гомдол гаргагч: Нэхэмжлэгч ... овгийн С.М-ийн өмгөөлөгч ...-ийн ... Хаяг: ... дүүргийн ... дугаар хорооны, ... тоотод		
	- аль шүүхийн ямар шийдвэрийг давж заалдаж байгааг даалгаврын өгөгдөлд тусгаснаар зөв бичсэн эсэх	Нэхэмжлэгч С.М-ийн өмгөөлөгч ... миний бие Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаартай шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдлыг гаргаж байна.		
	- гомдлын үндэслэлийг ялгагдахаар тодорхой тусгасан эсэх	Шалгах үзүүлэлтийн 2		
	- гомдлын шаардлага буюу давж заалдах шатны шүүхэд гаргаж байгаа хүсэлтээ тодорхой, ялгагдахаар бичсэн эсэх	Шалгах үзүүлэлтийн 3		
2	Гомдлын хууль зүйн үндэслэлийг тодорхойлсон байдал			
	- шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл түүний ямар үндэслэл, заалтыг зөвшөөрөхгүй байгааг дэлгэрэнгүй, тодорхой оновчтой зөв тодорхойлсон эсэх	Гомдлын үндэслэл: “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК Г.3-д Б.О-ийн цахилгааны дэд өртөөг шилжүүлэн өгөх техникийн нөхцөл шинээр олгохдоо өмнө нь холбогдсон хэрэглэгч нарыг дахин холбох тусгай шаардлагыг оруулаагүйгээс иргэн С.М-ын хууль олгогдсон эрх зөрчигдсөн. Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т захиргааны байгууллага гэж “үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа” гэж заасны дагуу нь “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК захиргааны байгууллагад хамаарна. Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т “Цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэрийн бүх хэрэглэгчийг түгээх сүлжээнд холбох үүрэгтэй”, 16.3-т “Цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь үүрэгтэй: 16.3.1.тухайн нутаг дэвсгэрт энэ хуульд заасан шаардлагыг хангасан хэрэглэгчийн шугам, тоног төхөөрөмжийг цахилгаан, дулаан түгээх шугам, тоног төхөөрөмжид холбох; 16.3.2.энэ хуулийн 9.1.13.-т заасан холболтын журмыг боловсруулах, батлуулах, мөрдөх; ...16.3.5.цахилгаан, дулаан		0-8

		<p>үйлдвэрлэх, дамжуулах, эрчим хүчээр зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэвийн үйл ажиллагаа болон хэрэглэгчийн цахилгаан, дулааны хэрэглээг найдвартай хангах; ... 16.3.7.энэ хуулийн 9.1.13-т заасан холболтын журмын шаардлага хангасан хэрэглэгчтэй урьдчилан тохиролцсоны үндсэн дээр энэ хуулийн 17.3-т заасан гэрээг байгуулж, тухайн хэрэглэгчийн шугамаас бусад хэрэглэгчийг холбох;" гэж тус тус зааснаар хариуцагч нь тусгай зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэрийн бүх хэрэглэгч, иргэн, аж ахуйн нэгжийг түгээх сүлжээнд холбох, хэрэглэгчийн цахилгаан, дулааны хэрэглээг найдвартай хангах, холболтын журмыг мөрдөх, түүнд хяналт тавих эрх, үүргийг хүлээнэ. Энэ чиг үүргийн хүрээнд "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК нь Г.3-д техникийн нөхцөлийг шинээр олгохдоо урьд уг техникийн нөхцлийг дагуу цахилгаанаар хангагдаж байсан айл өрхүүдийг үргэлжлүүлэн дэд өртөөнөөс цахилгаан эрчим хүчээр хангах үүрэг чиглэл өгөх эрх бүхий этгээд юм.</p> <p>Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д "Хэрэглэгч нь дараахь эрх, үүрэгтэй. ... 30.1.10.түгээх, зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах; 30.1.11.өөрийн шугам, тоног төхөөрөмжөөр дамжуулан эрчим хүч бусдад дамжуулах, түгээх, тухайн хангагчаас үйлчилгээний төлбөрийг гэрээний дагуу авах;" гэж заасан байдаг тул хариуцагч өөрийн тусгай зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэрийн бүх хэрэглэгчийг түгээх сүлжээнд холбох үүргээ хэрэгжүүлэх үүрэгтэй боловч энэ үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа.</p>	
	<p>Гомдлын шаардлагаа буюу давж заалдах шатны шүүхэд гаргаж буй хүсэлтээ тодорхойлсон байдал (ЗХШХШтХ-ийн 121 дүгээр зүйлийн 121.1 дэх хэсэг)</p>		
3	<p>- гомдлын шаардлага буюу давж заалдах шатны шүүхэд гаргаж байгаа хүсэлтээ даалгаврын өгөгдөлд нийцүүлэн оновчтой зөв тодорхойлсон эсэх</p> <p>(ЗХШХШтХ-ийн 121 дүгээр зүйлийн 121.1.2 дахь заалт)</p>	<p>Давж заалдах шатны шүүхэд гаргах хүсэлт</p> <p>Иймд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаартай шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэж өгнө үү.</p>	0-4

Эх сурвалж: https://shuukh.mn/single_case/9489?daterange=2026-01-03%20-%202026-03-10&id=2&court_cat=3&bb=1